# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ЭМГазар 2023.12.15

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Биелэлт | Үнэлгээ (хүчингүй болсон,хяналтаас хасуулах тухай) | Тасарсан болон удаашірсан байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ** | | | | | | |
| 1 | 1 | Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1997-06-05 Дугаар 1997.06.05 | 11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна. | Эрүүл мэндийн салбарын статистикийн бүртгэл мэдээллийг ЭМГ-ын СБМ-ийн алба үйл ажиллагааг удирдан явуулж, үүнд статистикийн мэдээ, мэдээлэл, мэдээний сан хариуцсан мэргэжилтэн-1, статистикийн оператор бага эмч 2 бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байна.<br>Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын сум, өрх, нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлгүүдэд орон тоогоор эрүүл мэндийн статистикийн бүртгэл мэдээллийг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх нийт 4 их эмч, 30 бага эмч нар ажиллаж байна. | | |
| | 2 | | 6.2 Мөнгө, зээл, санхүү, гааль, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын **эрүүл мэнд**, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг | 2023 оны эрүүл мэндийн салбарын 23 нэр төрлийн тоо мэдээ, тайланг ЭМЯ болон тусгай мэргэжлийн төвүүдэд сар, улирал, жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж хүргүүлсэн байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох яам, төрийн бусад албан газар тус тус эрхлэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд өгнө. | | | |
| 2 | 3 | Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай (Нэмэлт өөрчлөлт) 1999-07-01 Дугаар 2017.06.09 | 36.7. “Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт, өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зааврыг эрүүл мэндийн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” | Эрүүл мэнд, спортын сайд, хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 03 сарын 01-ний өдрийн 59, А/69 дугаар тушаалаар “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам” баталсан. Уг тушаалыг мөрдөн ажиллаж байгаа. Одоогоор өлсгөлөн зарласан тохиолдол байхгүй байна. | | |
| | 4 | | 25.2. Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн ажилтан ирж, үйлчлэх журмыг эрүүл мэнд, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | 2023 оны 11 сарын 20-ны өдөр аймгийн Прокурорын газрын удирдамжаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр, Цагдаагийн газрын саатуулах, баривчлах, эрүүлжүүлэх байранд хяналт шалгалт хийгдсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр нь их эмч 1, Цагдаагийн газрын саатуулах, баривчлах, эрүүлжүүлэх байр нь бага эмч 3 гэсэн эмнэлгийн мэргэжилтэнтэй, 2019 оны 03 сарын 29-ний өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/142, А/47 тоот тушаалаар батлагдсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-ыг баримтлан эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр нь 2023 оны 01 сарын 14-ний өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 4 хоригдогсдод нарийн мэргэжлийн эмчийн тусламжийг үзүүлсэн байна.<br>Цагдаагийн газрын саатуулах, баривчлах байр нь нэн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл хангалттай боловч эрүүл ахуйн шаардлага хангасан өрөө тасалгаа хангалтгүй, шаардлага бүхий ахуйн хэрэглээгээр хангаагүй, орчны нөхцөл шаардлага хангахгүй, хоногийн хоолны илчлэгийн хэмжээ бага байсанд тул зөвлөмж хүргүүлэн ажилласан. | | |
| 3 | 5 | Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-01-29 Дугаар 2015.01.29 | 9.4.Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах” 2022 оны 6 дугаар тогтоолын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв” дээр 18-аас дээш насны иргэдийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 25862 хүн хамрагдсан. Монгол улсын Засгийн Газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичиг, БХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг”-ийг Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторийн 4 ээлжийн 82 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, техникч, жолооч нар 98 хоногийн хугацаанд Архангай аймгийн 18 суманд нийт 8155 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 сарын 17-ны өдрийн А/256 дугаар тушаалыг дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн явуулын үзлэг Эрдэнэмандал, Тариат, Эрдэнэбулган суманд нийт 5 өдөр ажилласан. Үзлэгт нийт 390 хүн хамруулсан. Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт 34407 буюу хүн амын 36.1 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 1 иргэнд тооцож олгосон санхүүжилтээр 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, нийт 19307 хүүхэд үзлэгт хамрагдсанаас 39 хувь нь эрүүл, 61 хувь нь өвчтэй байна. 0-5 насны хүүхдийн өвчлөлийн 80 хувь, 6-17 насны хүүхдийн 88 хувь нь шүд цоорох өвчлөл | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эзэлж байна. | | |
| 4 | 6 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01 | 11.2. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Жолоочийн эрүүл мэндийн үзлэгийг ЭМС-ын 2000 оны 94 тоот тушаалаар баталсан Эрүүл мэндийн үзлэгийн хуудас ЭММ-34Б маягтыг эрүүл мэндийн үзлэг явуулах журмын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар үзлэгийг тогтмол хийж ажилладаг.<br>Эрүүл мэндийн газрын даргын 2023.04.26-ны 04/390 дүгээр албан бичгээр осол гэмтлийн үеийн анхан шатны тусламж /ухаан алдсан хүнд үзүүлэх анхны тусламж, цус алдалтын үеийн анхны тусламж/ сэдэвт сургалтыг аймагт үйл ажиллагаа явуулж буй жолооны Батлан хамгаалах, Лам гурван эрдэнэ, Цэнхэр буян авто сургалтын төвийн багш болон суралцагсад нийт 10 хүнд зохион байгуулж эрүүл мэндийн мэдлэг олгосон. | | |
| | 7 | | 11.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хүний амь насыг аврахад чиглэсэн эмнэлгийн дараах тусламж, үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлнэ:<br>11.1.1.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаар иргэнд чиглэсэн | Зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн байгууллагын яаралтай тусламж, үйлчилгээг ЭМС-ын холбогдох тушаал заавруудыг мөрдөн ажиллаж хамгийн ойр дуудлага авсан эрүүл мэндийн байгууллага баг гарган тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж байна.<br>Нийт амбулаторийн үзлэгийн 3.1%-ийг осол гэмтлийн шалгаант үзлэг эзэлж байна.<br>Нийт осолд гэмтэлд өртсөн 2751 иргэний 79.6% эмчилгээ үйлчилгээ авсан байна. Харин аймгийн хэмжээний нийт нас баралтын 20.4%-ийг буюу 90 тохиолдол зам тээврийн осол гэмтлийн шалтгаант нас баралт эзэлж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалт, сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэх;<br>11.1.2.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх;<br>11.1.3.зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн байгууллагын яаралтай тусламж, үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээний чанар, шуурхай байдлыг хангах;<br>11.1.4.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эмнэлэг, анхны тусламжийн цэг, харьяалагдах нутаг дэвсгэрийг тодорхойлох, ажиллах нөхцөл, боломжоор хангах;<br>11.1.5.тээврийн хэрэгслийн жолооч болон жолооч бэлтгэх сургалтад хамрагдах иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах. | Мөн тээврийн хэрэгслийн жолооч болон жолооч бэлтгэх сургалтад хамрагдах иргэнийг нарийн мэргэжлийн эмчийн эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байна. | | |
| 5 | 8 | Эрүүл ахуйн тухай хууль<br>2016-02-04<br>Дугаар 2016.02.04 | 4.5.. Энэ хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. (4.4.2.хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог | Аймгийн эрүүл мэндийн салбарын эмнэлгийн аюултай хог хаягдлын мэдээг сар бүр нэгтгэн дүгнэлт хийж, эргэн мэдээллээр хангаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн гаралтай хог хаягдлын мэдээг ХӨСҮТ-ийн ХӨТСА-нд сар бүр мэдээллэж ажилласан. 2023 оны 11 сарын байдлаар нийт 11688.8 кг халдвартай, 4168.9 кг хурц үзүүр иртэй, 140.2 кг эмгэг, 113.9 кг эмийн, 520.3 кг химийн хог хаягдлыг гарсан.<br>Аймгийн 19 сумын эрүүл мэндийн төвд халдварын сэргийлэлт хяналт, хог хаягдлын менежментийн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах;) | байдалд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлсэн.<br>Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд "Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналт" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн 16 эмч, мэргэжилтнүүдэд оролцож мэдлэгээ дээшлүүлсэн.<br>18 сумын эрүүл мэндийн төвд хог хаягдал халдваргүйжүүлэх автоклаваар хангасан. | | |
| | 9 | Эрүүл мэндийн тухай хууль | 12.1.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>12.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах; | Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж улирал тутам тайлагнан ажиллаж байна. Албан даалгаврын биелэлтийн хувь 94.2% байна. | | |
| | 10 | | 12.1.3.эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А 475 дугаар тушаалын аргачлалын дагуу тогттсон хязгаарт нийцүүлэн эмнэлэг рашаан сувилалын орны тоо, ор хоног, амбулаторийн үзлэгийн хуваарийг ЭМГ-ын даргын А/37 дугаар тушаалаар батлан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн мөрдлөг болгон ажиллаж байна. | | |
| | 11 | | 12.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих; | ЭМГ-ын даргын 2023 оны А/05, А/14, А/68, А/74 тоот тушаалаар аймгийн НЭ, сум өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хийгдэх дэмжлэгт хяналтын хуваарийг батлан 2023 онд 46 байгууллагад давхардсан тоогоор 92 удаагийн дэмжлэгт хяналтыг хийн зөвлөмж, илтгэх хуудсыг ЭМГ- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ын албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажилласан.<br>Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023 оны 03 сарын 01-03-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын 2022 оны ололт амжилт, 2023 оны дэвшүүлэх зорилго, анхаарах чиглэл, анхан шат болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний уялдаа холбоо, эрт илрүүлгийн хамрагдалтыг сайжруулах чиглэлээр мэдээлэл өгч, харилцан санал солилцсон. | | |
| | 12 | | 12.1.5.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх. | ЭМСайдын А/611 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн салбарын статистикийн мэдээ, тайланг өдөр бүр, 7 хоног тутам, сар, улирал, жилээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв-3, сумын эрүүл мэндийн төв-19, хувийн хэвшлийн оргүй 11, ортой 5 нийт 39 эрүүл мэндийн байгууллагаас цаг тухайд нь мэдээллийг авч нэгтгэн гаргаж, мэдээний дагуу сар, улирал, жилийн эргэн мэдээллийг бэлтгэж ЭМЯам, тусгай мэргэжлийн төвүүд болон холбогдох байгууллагуудад хүргүүлж байна. | | |
| | 13 | | 12.2.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө. | Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрхийн дагуу 2 сумын эрүүл мэндийн төвийн даргыг томилорлд саналыг хүргүүлсэн. | | |
| | 14 | | 19.2.Улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаа үйл ажиллагааны чиглэлээр эрүүл мэндийн болон аж ахуй нэгж байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг. Архангай аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт 123 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийг эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн бусад байгууллагад аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага” гэх/ олгоно. | эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.<br>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь Эрүүл мэндийн тухай хуулийн 19.2 дугаар зүйлд заасны дагуу ЭМГ-ын даргаар ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.<br>2023 оны байдлаар шинээр эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 8 материал ирснээс 6 байгууллагад үйл ажиллагааны шаардлага хангасан гэж үзэж тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. Хоёр байгууллагын хүсэлт материал бүрдүүлбэр хангуулах шатанд явж байна.<br>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгуулсан-2, нэмэлт өөрчлөлт хийлгэсэн – 5 байгууллага, хүчингүй болгосон 2 эрүүл мэндийн байгууллага байна.<br>2023 онд тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол байхгүй. | | |
| | 15 | | 26.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны Ёс зүйн хяналтын хороо, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дэргэд ёс зүйн салбар хороо, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төвийн дэргэд Анагаах ухааны ёс зүйн хяналтын салбар хороо тус тус ажиллана. Ёс зүйн | ЭМг-ын дэргэд ёс зүйн салбар хоро, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд ёс зүйн хэсгийн хороо, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дэргэд ёс зүйн баг нь ЭМСайдын 2019 оны 406 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн энэ чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хяналтын хороо, салбар хорооны үлгэрчилсэн дүрэм, анагаах ухааны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | | | |
| | 16 | | 35”1.1.Монгол Улсын иргэнийг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн товлосон хугацаанд хамруулна. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв” дээр 18-аас дээш насны иргэдийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2023 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар Нэгдсэн эмнэлэгт нийт 25862 хүн хамрагдсан. Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторийн явуулын үзлэг 18 суманд нийт 8155 иргэн хамруулсан бол Эрүүл мэндийн сайдын А/256 дугаар тушаалыг дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн явуулын үзлэг Эрдэнэмандал, Тариат, Эрдэнэбулган суманд нийт 390 хүн хамруулсан. Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт 34407 буюу 36.1 хувь нь хамрагдсан байна. Үзлэгээр элэгний хавдар 10, ходоодны хавдар 7, улаан хоолойн хавдар 2, умайн хүзүүний хавдар 3 илэрсэн байна. Мөн й6-17 насанд 8 хавдрын тохиолдол илэрсэн. | | |
| | 17 | | 42.1.Эрүүл мэндийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, шалгах, дүгнэх, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар шалгалт хийх, шалгалтын дүнг мэдээлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг буруутай албан тушаалтнаар арилгуулах, хууль тогтоомж | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 10-00/17 дугаартай удирдамжаар төлөвлөсөн 30 эрүүл мэндийн байгууллагыг 100% хамруулан 6 төрлийн хяналтын хуудсаар хяналт шалгалтыг хийхэд 13 байгууллага буюу 43.3.% нь “бага” эрсдэлтэй, 13 байгууллага буюу 43.3% нь “дунд” эрсдэлтэй, 4 байгууллага буюу 13% нь их эрсдэлтэй тус тус дүгнэгдсэн.<br>Шалгалтын мөрөөр эмнэлэг тус бүрт танилцуулга үйлдэж илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар улсын | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөрчсөн гэм буруутай этгээдэд энэ хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх чиг үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналт хариуцсан алба хэрэгжүүлнэ. | байцаагчийн 204 заалт бүхий 15 албан шаардлагыг тус тус хүргүүлэн гүйцэтгэлийн шалгалтыг газар дээр нь хийж гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэлийн шалгалтаар албан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан 2 эрүүл мэндийн байгууллагад "Зөрчлийн тухай" хуулийн 15.1.2 дахь заалтаар 1000000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч ажиллаа. | | |
| 6 | 18 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай<br>2016-04-22<br>Дугаар 2016.04.22 | 7.3. Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна. | "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэх журам"-ын дагуу болон өрх, сумын эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагаа орон тооноос хамааран эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулан ажиллаж байна. | | |
| | 19 | | 15.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ТУЗ-ийг байгуулах гишүүдийг сонгон шалгаруулсан боловч ЭМЯ-наас зөвшөөрөл чиглэл нь ирээгүй тул ТУЗ байгуулах ажил хойшлогдоод байна. | | |
| 7 | 20 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/<br>2016-12-22<br>Дугаар 2017.02.01 | 15.1.1. Энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан нэг цэгийн үйлчилгээ, энэ хуулийн 38.1.2-т заасан сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх; | Архангай аймагт уг 1 цэгийн үйлчилгээ байхгүй хэдий ч хүчирхийлэлд өртсөн иргэд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагаас авах боломжтой.<br>Эрүүл мэндийн дүн бүртгэлийн сар бүрийн мэдээнд осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөлийн мэдээг сар бүр эрүүл мэндийн байгууллагуудаас авч мэдээний сан үүсгэсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Түр хамгаалах байранд эхний 5 сарын байдлаар хамтарсан багаар дамжуулан 9 хүүхэд, 5 насанд хүрсэн эмэгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.<br>Хүчирхийлэлд өртсөн иргэд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагаас авах боломжтой.<br>Эрүүл мэндийн дүн бүртгэлийн сар бүрийн мэдээнд осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөлийн мэдээг сар бүр эрүүл мэндийн байгууллагуудаас авч мэдээний сан үүсгэсэн. | | |
| 8 | 21 | Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай<br>2017-05-12<br>Дугаар 2017.05.12 | 14.2.2.. эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах; | Монгол улсын эрүүл мэндийн А/481 дүгээр тушаалаар батлагдсан нялх балчир хүүхдийг хооллох зааврын дагуу эцэг эхчүүд болон Эрүүл мэндийн байгууллагын ажилчдад мэдээллийг хүргэж байна.<br>Эхийн сүүгээр хооллолх 10 алхам зурагт хуудсыг эрүүл мэндийн байгууллагуудад байршуулсан.<br>Нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтанд гурван сургагч багш хамруулсан. | | |
| 9 | 22 | Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/<br>2017-12-07<br>Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Монгол Улсын ЗГ-ийн 2019 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 17-ны өдрийн А/237 дугаар захирамжаар баталсан эрүүл мэндийн салбарын ажилчдын нийгмийн баталгааг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд 2020-2023 оны эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс 2.1 тэрбум төгрөгний хамгаалах хувцас хэрэгсэл, 22.4 сая төгрөгний халдваргүйжүүлэлтийн бодисын хангалтыг хийж, тусламж үйлчилгээнд ашигласан. Эмнэлгийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, аймгийн Засаг даргын нөөц сангаас 1116 ажилтанд 8,199,500 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | төгрөгний дархлаажуулалтын багцыг олгож, “КОВИД-19” коронавирусын 1, 2-р тунгийн дархлаажуулалтад 863, 3-р тунгийн дархлаажуулалтад 642, элэгний В вирусын халдварын дархлаажуулалтад 237, томуугийн дархлаажуулалтад 1168 хүнийг хамруулсан.<br>ЭМХТ, ЭМГ болон бусад байгууллагуудаас эрүүл мэндийн байгууллагуудын ажилтануудад ZOOM програм ашиглан 126 удаа сургалт, хурал зохион байгуулж, цахим сүлжээг ашиглан давтагдсан тоогоор 6097 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулсан. Дотооддоо зохион байгуулсан богино хугацааны сургалтад давхардсан тоогоор 24002 гаруй хүн хамрагдсан нь 1 ажилтан 22 удаагийн сургалтад хамрагдсан үзүүлэлттэй байна.<br>2020-2023 оны эхний хагас жилийн төгсөлтийн дараах сургалтад 209 эмч мэргэжилтэнг хамруулснаар нийт эмнэлгийн мэргэжилтэний 24.3 хувийг урт хугацааны сургалтад хамруулсан. 10 эмнэлгийн мэргэжилтэн удирдлагын мэргэшүүлэх сургалтад хамруулж, гадаад сургалтад 14 хүнийг танхимаар, 4 хүнийг цахимаар хамруулсан. | | |
| 10 | 23 | Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ 2018-01-19 Дугаар 2018.01.19 | 22.1. Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг | ЭМГ-ын даргын 2023 оны 01 сарын 17-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Сайн дурын авлагагүй цусны донороос-цус цуглуулах үйл явц” сургалтын удирдамж, цус цуглуулах үйл ажиллагаанд оролцох сум, эмнэлгийн мэргэжилтний хуваарийг гарган батлуулж 20 ЭМБ-д хүргүүлсэн.<br>ЭМГ-ын даргын А/01 тушаалын хэрэгжилтийн хүрээнд хуваарийн дагуу 10 сумын эрүүл мэндийн төвийн 26 эмч, мэргэжилтэнд сургалт хийж, 83 донорыг үнэгүй үзлэг, шинжилгээнд хамруулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон донор 1200 гаруй хүнд цусны салбар төвөөс сургалт, зөвөлгөө мэдээлэл хийж ажилласан.<br>Мөн 16 сумын эрүүл мэндийн төвийн 17 сувилагчийг цус цусан бүтээгдэхүүн цуглуулах үйл ажиллагаа, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | цусны аюулгүй байдал, хадгалах, тээвэрлэх ур чадварт Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвд 2 хоёр хоног дадлагажуулан сургасан.<br>Одоогоор дотоодын рашаан сувилалд үнэ төлбөргүй сувилуулсан донор байхгүй байна. | | |
| 11 | 24 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай<br>2019-05-30<br>Дугаар 2019.05.30 | 10.2.5. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журмыг мэргэжлийн хяналтын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах; | Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт, хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай” А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалын дагуу сургуулийн хүүхдэд олгож буй хоол хүнсэнд хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтөд шаардлагатай шим тэжээл, амин дэм, илчлэгийн норм хэмжээнд жил бүр үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж байна. | | |
| | 25 | | 10.4.1. Сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааг таван жил тутамд гаргаж, үр дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх; | Хүүдийн хоол тэжээлийн байдлын зургаадугаар судалгаанд архангай аймгийн зургаан сургуулийн 6-18 насны 112 хүүхдийг хамрагдсан бөгөөд судалгааны дүн нэгтгэлт үргэлжилж байна. | | |
| | 26 | | 10.4.2. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг батлах; (10.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ) | ЭМС-ын 2021 оны А/370, А/360 дугаар тушаалаар сургуулийн орчинд хүүхдэд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад хийжүүлсэн, давс, чихрийн агууламж өндөр, транс тос агуулсан гэх мэт 11 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хориглосон.<br>Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг бүх сургуулийн удирдлагад хүргүүлж, сургууль орчимд худалдаалахыг бүрэн хориглох зөвлөмж хүргүүлсэн. | | |
| | 27 | | 10.4.3.. Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг | Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэг, хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай” А/166, А/559, 222 дугаар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хэмжээг үндэслэн сургуулийн хүүхдийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээл, илчлэгийн хэмжээг тодорхойлох; | тушаал”, ЭМС-ын 2020 оны “Хүн амын эрүүл хооллолтын зөвлөмж” батлах тухай А/215 дугаар тушаалын дагуу сургуулийн хүүхдийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээл, илчлэгийн хэмжээг тогтоон сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд мөрдөн ажиллаж байна. | | |
| | 28 | | 10.4.4. Тусгай хоолны дэглэмтэй хүүхдэд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоолны жишиг цэс, зөвлөмж гаргах; | Эрүүл мэндийн сайдын 2018 оны 16 дугаар тушаалаар “Хоол эмчилгээний удирдамж”, 481 дүгээр тушаалаар “Нялх балчир хүүхдийн хооллох заавар”, 2020 оны А/215 дугаар тушаалаар “1-6 насны хүүхдийн эрүүл хооллолтын зөвлөмж”, “Өсвөр үеийнхний эрүүл хооллолтын зөвлөмж”-ийг тус тус батлан хүүхдийн байгууллагын болон хүүхдийн эмнэлгийн хоол үйлдвэрлэлд мөрдөн ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хэрхэн хооллох вэ? зөвлөмж бэлтгэн эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүргүүлсэн. | | |
| | 29 | | 10.4.5.. Энэ хуулийн 10.4.1-д заасан судалгаанд үндэслэн хүүхдийн зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах; | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/215 дугаар тушаалаар батлагдсан “1-6 насны хүүхдийн эрүүл хооллолтын зөвлөмж”, “Өсвөр үеийнхний эрүүл хооллолтын зөвлөмж”-ийг бүх сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлсэн.<br>Эрүүл хүнс ямар байдаг вэ? Цуврал постеруудыг бэлтгэн сар бүр олон нийтэд түгээж байна. Мөн эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн сонгон хэрэглэх, зөв зохистой хооллох, хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээлэлтэй танилцах талаар сургалтуудыг цэцэрлэг сургуулийн насны хүүхэдтэй 150 гарвуй эцэг эхчүүдийг хамруулан зохион байгуулсан. | | |
| | 30 | | 10.4.6..Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтад заасны | Сургуулийн хүүхдийн хоолны цэс, технологийн картын Edison.edu.mn сайтаар хянаж, сайжруулах шаардлагатай хоол тэжээлийн зөвлөмжийг БШУГ-ын даргад хүргүүлсэн. Мөн сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулах, хүүхдийн хоолны | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дагуу сургууль дээр тандалт судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг мэдээлэх. | шим тэжээлийн боловсрол олгох онлайн сургалт зохион байгуулж сургууль цэцэрлэгүүдийн удирдлага, нярав тогооч нарыг хамруулсан. | | |
| 12 | 31 | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | 7.1.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах; | Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/36 дугаар тушаал, “Коронавируст халдварын тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээг шинэчлэх тухай”, А/203 дугаар тушаал, “Коронавируст халдварын тархалтын үе шат, түвшинг үнэлэх тухай” тушаалуудыг баримтлан хариу арга хэмжээг зохион байгуулж байна. | | |
| | 32 | | 7.1.11.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; | Халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгааны материалыг Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд тухай бүр байршуулсан.<br>Халдвараас урьдчилан сэргийлэх болон халдварын нөхцөл байдал, коронавирүсийн эсрэг вакцинжуулалтын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагад Эрүүл мэндийн газраас 2023 он 2 удаа мэдээлэл өгсөн. Халдварын тархалт улаан түвшинд шилжсэн үед аймгийн Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд халдварын нөхцөл байдал, цаг үеийн асуудлын талаар өдөр бүр мэдээлэл оруулж байсан.<br>Коронавируст халдварын нэмэлт тунгийн ач холбогдлын талаар төрийн байгууллагуудад зөвлөмж, мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн.<br>Орон нутгийн “АВ” телевизээр дамжуулан коронавируст халдвар, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын ач холбогдлын талаар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | НЭМҮТ-өөс ирүүлсэн 2 төрлийн видео шторкыг олон нийтэд хүргэсэн. | | |
| | 33 | | 7.1.13.Төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах; | Эрүүлжүүлэх байр, цагдан хорих байруудад халдвараас сэргийлэх дэглэмийг хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн. Эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай тохиолдол бүрт эмнэлгийн тусламж үйлчилгээг тухай бүр хүргэж байна. | | |
| | 34 | | 7.1.15.. Цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэх; | Хэвийн горимд шилжин ажиллаж байгаа тул хүнсний нөөц хангалт хэвийн хэмжээнд байна. | | |
| | 35 | | 7.1.16. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх | Хэвийн горимд шилжин ажиллаж байгаа тул ковид цар тахалтай холбоотой зардал гараагүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; | | | |
| | 36 | | 7.1.17. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах журмыг батлах; | Төрийн болон хувийн хэвшлийн 34 байгууллагад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг байгууллагын орчинд бүрдүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд багш, ажилчид, суралцагчдыг амьсгалын замын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Боловсрол шинжлэх ухааны газраар дамжуулан хүргүүлсэн.<br>Орон нутгийн “АВ” телевизтэй хамтран коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын ач холбогдлын талаар 2 төрлийн видео шторк бэлтгэн телевиз болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. | | |
| | 37 | | 7.1.21.. Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох; | 2023 онд цар тахлын халдвараар өвчилсөн болон өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох тохиолдол бүртгэгдээгүй. | | |
| | 38 | | 7.1.23.. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, хэрэгслээр иргэдийг тэгш, хүртээмжтэй хангах; | Эмнэлгийн тусалж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр 2023 оны тендерийн эм, ороох боох материалыг Архангай аймгийн засаг даргын 2023 оны 05 сарын 08-ны А/267 захирамжийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтаар гэрээ байгуулан худалдан авалт хийж ажиллаж байна. | | |
| | 39 | | 9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, | Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/36 дугаар тушаал, “Коронавируст халдварын тархалтын түвшинд тохирсон хариу арга | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | хэмжээг шинэчлэх тухай”, А/203 дугаар тушаал, “Коронавируст халдварын тархалтын үе шат, түвшинг үнэлэх тухай” А/207 дугаар тушаал, “Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэх тухай” А/33 дугаар тушаал, “Коронавируст халдварын дараах хам шинжийн оношилгоо, эмчилгээний түр заавар батлах тухай” А/435 дугаар тушаалуудыг коронавируст халдварын эсрэг хариу арга хэмжээнд мөрдөн ажиллаж байна.<br>2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 231 сорьцонд КОВИД-19-ын ПГУ шинжилгээ хийх 20 зэрэг тохиолдлыг илрүүлсэн, оношлуурын нөөц 1047 байна. Энэ хугацаанд ХӨСҮТ-ийн лавалгаа лабораторийн чанарын 1 удаагийн хяналтанд хамрагдан баталгаажилт хийгдсэн. Харин КОВИД-19 антиген илрүүлэх түргэчилсэн шинжилгээг 3284 хүнд хийж 92 зэрэг тохиолдлыг илрүүлсэн. | | |
| | 40 | | 9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах зааврыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | 2023 онд өмнөх оны ковид-19 цар тахлын эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис хадгалалтын горимоор хангалттай нөөцтэй байна. | | |
| | 41 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 | 13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөөг 3 бүлгийн хүрээнд 23 зорилт 113 арга хэмжээ төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт 81.7 хувь | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | 42 | Дугаар 2020.07.01 | 21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 2023 оны тайланг хагас бүтэн жилийн байдлаар гарган аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. | | |
| 14 | 43 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02 | 19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх; | Эрүүл мэндийн газрын ажилчдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг гарган хугацаанд нь ЗДТГ-т хүргүүлсэн. | | |
| 15 | 44 | | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Цахим хуудас ar.mohs.gov.mn, байгууллагын мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг ил тод байршуулсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | |  | | |
| 16 | 45 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Байгууллагын ил тод мэдээллийн самбар, цахим хуудаснуудад чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл өнгө үзэмжтэй ил тод байршуулсан.  | | |
| | 46 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Эрүүл мэндийн салбарын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд 19 байгууллага зөрчилгүй, 3 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авсан.<br>Бүх ЭМБ-уудын аудитын шийдвэрүүдийг байгууллага бүрээр нэгтгэн гаргахад нийт 15 акт 58253,7 мянган төгрөгний, 23 албан шаардлага 132421,7 мянган төгрөгний, 12 зөвлөмж 1355901,8 мянган төгрөгний, нийт 1546577,2 мянган төгрөгийн ямар нэгэн зөрчил илэрсэн ба уг мэдээллийг 2022-04-10-нд ЭМЯ-нд хүргүүлсэн. Мөн ЭМБ-уудад аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах 2023.04.19-ний өдрийн 02/348 тоот, аудитын зөвлөмжийн биелэлт гаргаж ирүүлэх, анхааруулах 2023-06-12-ны өдрийн 02/570 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлэн ажиллаж аудитын зөвлөмжийн биелэлт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллүүдийг нэгтгэн 2023.04.08-ны өдрийн 02/559, 2023-08-18-ны өдрийн 02/692 тоот албан бичгүүдээр | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. | | |
| | 47 | | 8.2.4. Ил тод байдлын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Ил тод байдлын тухай хуулиар байгууллагын чиг үүрэг, ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээний улсын шалгалтанд 94.57% “А” үнэлгээтэй үнэлгэгдсэн. | | |
| | 48 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөөг 3 бүлгийн хүрээнд 23 зорилт 113 арга хэмжээ төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийн тайланг гарган ЗДТГ-д хүргүүлсэн. | | |
| | 49 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЭМЯ, аймгийн ЗДТГ-т хүргүүлэн ажиллаж байна. | | |
| | 50 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | ЭМГазарт холбогдох байгууллага, иргэдээс ажлын цагаар бичиг хэргийн ажилтанд санал гомдлыг биеээр болон бичгээр хүлээн авч, байгууллагын дарга болон ёс зүйн хороонд танилцуулж, цохолт хийсэн холбогдох мэргэжилтэн, албан тушаалтанд хүлээлгэн өгөн шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд албан бичгээр, утсаар хариуг эзэнд мэдээлж байна. Эрүүл мэндийн газарт 2023 оны байдлаар нийт 49 өргөдөл ирснээс 46 нь бүрэн шийдвэрлэгдэж, 3 нь шилжүүлсэн байна. Шийдвэрлэлтийн хувь 100 хувь. Нийт ирсэн өргөдлийн 33 нь бичгээр, 1 нь биечлэн уулзаж, Засгийн газрын 11-11 төвөөр 15 гомдол ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 51 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Сар, улирал болон жилийн эцсийн эрүүл мэндийн салбарын эргэн мэдээллийг ЭМБ-ууд болон дээд шатны байгууллагуудад тухай бүрт нь мэдээллэж, ЭМГ-ын цахим сайтад нээлттэй мэдээллэж байна. | | |
| | 52 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | ЭМГ-ын сул ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд уламжилсан. Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай 45 орон тооны мэдээллийг авч ЭМГ-ын вэйб сайтад байршуулсан. | | |
| | 106 | | 1.13.. Иргэдийн нас баралтад нөлөөлж байгаа өвчин эмгэгийн байдалд судалгаа хийж, өвчлөлийг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, санхүүжилтийг шийдвэрлэх. | Архангай аймгийн хүн амын өвчлөл, нас баралтын сүүлийн 5 жилийн үзүүлэлтэд судалгаа хийхэд хүн амын өвчлөлийн зонхилох шалтгаан нь насанд хүрэгчдэд зүрх судас, бөөр шээсний зам, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, хүүхдэд амьсгалын замын болон шүд цоорох өвчлөл байна.Нэгдсэн эмнэлэгт 18-аас дээш насны нийт 25862 хүн хамрагдсан. Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторын явуулын үзлэгт 18 суманд нийт 8155 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдын А/256 дугаар тушаалыг дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн явуулын үзлэг Эрдэнэмандал, Тариат, Эрдэнэбулган суманд нийт эрт илрүүлэг үзлэгт 390 хүн хамруулсан.Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 34407 буюу 36.1 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 1 иргэнд тооцож олгосон санхүүжилтээр 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, нийт 19307 хүүхэд үзлэгт хамрагдсанаас 39 хувь нь эрүүл, 61 хувь нь өвчтэй байна. 0-5 насны хүүхдийн өвчлөлийн 80 хувь, 6-17 насны хүүхдийн 88 хувь нь шүд цоорох өвчлөл ээзлж байна. | | |
| | 107 | | 1.14.. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах. | Дэмжлэгт хяналтын хүрээнд 18 суманд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангуудад хянан шалгалт хийсэн ба алдаа зөрчлийг газар дээр нь засаж залруусан. Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн хадгалалт, хугацаа хэтэрсэн зөрчил гарсан бөгөөд Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал хариуцсан улсын байцаагчид тухайн зөрчлийг баримтжуулан дүгнэлт гарган гомдлыг хүргүүлсэн.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардлагатай 2023 оны эм эмнэлгийн хэрэгслийн тендерийг Орон нутгийн өмчийн албанд хүргүүлэн тендерийг зарлаж 2023 оны А/267, тоот захирамжаар шалгарсан багцын гэрээг байгуулан ажиллаж дууссан. | | |
| Хэсгийн дундаж хувь 92% | | | | | | |
| **ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ** | | | | | | |
| 33 | 108 | Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц - чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03 | 2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох; | Аймгийн хэмжээнд иргэдэд нийтлэг хэрэглэгддэг эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн үнийн хяналтыг Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 4 эм ханган нийлүүлэх байгууллага, 62 эмийн сангуудад хийсэн. | | |
| | 109 | | 6. Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох | Эрүүл мэндийн салбарын эмч ажилчдаас тусгай зөвшөөрөлгүй биологийн идэвхт бүтээгдэхүүн худалдан борлуулах үйлдэл илрээгүй болно. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хэсгийн дундаж хувь 90% | | | | | | |
| **ҮАБЗ-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | |
| 34 | 110 | Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | 6. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | Газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдалтай холбоотойгоор Архангай аймгийн Онцгой байдлын газраас ЭМГ-ын ажилчид ЗООНОЗ, НЭ-ийн мэргэжлийн анги, Эрүүл мэндийн албаны штабын бие бүрэлдэхүүнийг хамруулан нийтдээ 5 удаагийн сургалтаар 136 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан.<br>ЭМ-ийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүнд тодотгол, шинэчлэл хийсэн. Үүний хүрээнд стратегийн команд штабын сургуулилтын хүрээнд болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг аймгийн засаг даргын 2023.05.15-ны өдрийн А/286 дугаар захирамжаар 6 ангийн 79 мэргэжилтний судлагааг шинэчилсэн. ЭМЯ-д болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарт бүрдүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис болон бусад нөөцийг ЭМБ-аас авч нэгтгэн холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн.<br>Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны танилцуулга, төлөвлөгөөг шинэчилж ОБГ-ын ГХТББ хариуцсан улсын байцаагчаар батлуулан хэрэгжүүлж байна.<br>Гамшгийн үед “Цугларах цэг”-г байгууллагын хашаан дотор аюулгүй хэсэгт стандартын дагуу шинэчилж хийж, аюулгүй байдлыг ханган байрлуулсан.<br>Мөн 06 сард Дархан-Уул аймагт Тохиолдлын удирдлагын тогтолцоо, ослын удирдлагын тогтолцооны удирдах бүрэлдэхүүний академик 2 өдрийн сургалтад ОБГ, ЭМГ-ын холбогдох удирдлага, мэргэжилтэн 5 хүн сургалтад хамрагдсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хэсгийн дундаж хувь 100% | | | | | | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ** | | | | | | |
| 35 | 111 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай<br>2018-08-22<br>Дугаар 2018_258 | 1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай:<br>1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | Төрийн албаны сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай ЗГ-ын А/258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/433 дугаар захирамж, аймгийн ЗДТГ-ын 03/892 дугаар албан бичгийг үндэслэн салбарын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон. Мөн тогтоол, захирамж, чиглэл хүргүүлснээс хойш гарсан зөрчлүүдэд дүгнэлт хийн анхааруулгыг бүх эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>ЭМГ-ын даргын тушаалаар жил бүр эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналтыг хийж зөвлөмж чиглэлийг өгч ажилласан. Хяналтаар эрүүл мэндийн байгууллагуудад халдвар хамгаалал, хяналт, анхан шатны маягт хөтлөлт, эмчилгээ оношилгооны стандарт мөрдөлт хангалтгүй байсанд дүгнэлт хийн залуу эмч нарын мэдлэг сэргээх сургалт, статистикч эмч нарын танхимын сургалт, халдвар хяналтын багийнханд бүсчилсэн сургалтыг хийсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой байгууллагын дарга, хүний нөөцийн ажилтнуудад сургалт хийж 65 хүнийг хамруулсан. Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах үүднээс багийн эмч нар болон хүүхдийн эмч нарт ХӨЦМ-ийн 3-5 хоногийн сургалтыг хийж 102 хүнийг хамруулсан. | | |
| | 112 | | 1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, | Байгууллагын ил тодын самбар болон ЭМГ-ын вэб сайтад өргөдөл хүлээн авах ажилтны мэдээлэл, журмыг тодорхой тавьсан. ЭМГазарт холбогдох байгууллага, иргэдээс ажлын цагаар бичиг хэргийн ажилтанд санал гомдлыг биеэр болон бичгээр хүлээн авч, байгууллагын дарга болон ёс зүйн хороонд танилцуулж, цохолт хийсэн холбогдох мэргэжилтэн, албан тушаалтанд хүлээлгэн өгөн шийдвэрлүүлж, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх; | хуулийн хугацаанд албан бичгээр, утсаар хариуг эзэнд мэдээлж байна. Эрүүл мэндийн газарт 2023 оны байдлаар нийт 49 өргөдөл ирснээс 46 нь бүрэн шийдвэрлэгдэж, 3 нь шилжүүлсэн байна. Шийдвэрлэлтийн хувь 100 хувь. Нийт ирсэн өргөдлийн 33 нь бичгээр, 1 нь биечлэн уулзаж, Засгийн газрын 11-11 утсаар дамжуулан 15 гомдол ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлсэн. | | |
| | 113 | | 1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв, ЗӨСТ-ийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан ЭМГ-ын даргын А/175 тоот тушаалаар баталгаажуулан, мөрдлөг болгон ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу сумын эрүүл мэндийн төвүүдийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг боловсруулан хүргүүлсэн.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүтээмжийн урамшуулал тооцон олгож эхэлсэн. | | |
| | 114 | | 1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | Эрүүл мэндийн газрын сул орон тооны ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Архангай дахь салбар зөвлөлд ЭМГ-ын албан бичгээр удаа дараалан хүргүүлсэн. Захиалгын дагуу сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөс хуулийн хүрээнд зохион байгуулж, 11 хүнийг томилгоожуулсан. | | |
| | 115 | | 1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр | Эрүүл мэндийн газрын сул орон тооны ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Архангай дахь салбар зөвлөлд ЭМГ-ын албан бичгээр удаа дараалан хүргүүлсэн. Захиалгын дагуу сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөс хуулийн хүрээнд зохион | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох; | байгуулж, 11 хүнийг томилгоожуулсан. | | |
| | 116 | | 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | ЭМГ-т гэрээт ажилтан байхгүй болно | | |
| | 117 | | 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, | Эрүүл мэндийн байгууллагууд албан хаагчдыг ажлын байранд болон албан томилолтоор ажиллах хугацаанд архидан согтуурахгүй байх, ажлын байранд согтууруулах ундаа, тэсэрч дэлбэрэх бодис, хурц үзүүртэй зүйл хадгалахгүй байх талаар байгууллагын дотоод журмандаа тусгаж өгсөн ба одоогоор дотоод журмын уг заалтыг зөрчиж хариуцлага тооцуулсан тохиолдол гараагүй байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | | | |
| | 118 | | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийн талаар мэдлэх олгох чиглэлээр Эрүүл мэндийн салбарын ажичлдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургагч багштай хамтран 2023 оны 03 сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн газрын албан хаагчдад “Төрийн албан хаагчдын ёс зүй” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтад Эрүүл мэндийн газрын 15 албан хаагч хамрагдсан.<br>2023 оны 04 сарын 11-ний өдөр НЭ-ийн дэргэдэх ёс хэсгийн хороо, ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар зөвлөл, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ёс зүйн багийн албан хаагчдад ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн хяналтын хорооны дарга Д.Оюунбилэгтэй хамтран ёс зүйн салбар хороо, хэсгийн хороо, ёс зүйн багуудыг чадавхжуулах сургалтыг цахимаар болон тэнхимээр зохион байгуулсан.<br>Эерэг өөрчлөлт, сайн сайхан Ану хүрээлэн, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн хяналтын хороотой хамтран “Эрүүл мэндийн байгууллагын соёлд авлига, ёс зүйн асуудлыг хөндөх нь” сэдэвт 2 кредит төлбөртэй сургалтыг 2023 оны 04 сарын 12-ны өдөд цахимаар зохион байгуулан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилчид 20 албан хаагчид хамрагдан мэдлэгээ дээшлүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Аймгийн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Архангай аймгийн ЗДТГ-ын дэмжлэгээр "Эерэг хандлагатай Архангай" аяны хүрээнд 2023 оны 04 сарын 29-ний өдөр НЭ, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын ажилчдын хамруулан МУБИС-ийн Архангай аймаг дахь багшийн сургуулийн сургалтын тэнхимд “Эерэг хандлага-аз жаргалтай амьдрал" сэдэвт өөрчлөлтийг өөрөөсөө эхлэх энгийн боловч гайхалтай үр дүнтэй 8 дасгалыг амьдралдаа хэрхэн ухамсартайгаар хэрэгжүүлэх аргад суралцах сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад хамрагсдад гэрчилгээ олгосон үр дүнтэй сургалт болсон.<br>Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийг угтан 2023 оны 05 сарын 07-ны өдөр ЗДТГ-ын хурлын тэнхимд аймгийн НЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг сайжруулах, сэтгэлзүйг дэмжих зорилгоор Нью-Даймонд Академийн “Хүний хөгжил-Төрийн албан хаагчдын ёс зүй”-н мэдлэг олгох олон улсын хөтөлбөр бүхий хувь хүний хөгжлийн сургалтыг мэргэжлийн багш урин зохион байгуулсан бөгөөд сургалтад эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөл 250 хүн хамрагдсан.<br> | | |
| | 119 | | 1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын | 2022 оны 05 сараас хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хурууны хээний бүртгэлийг хэрэглээнээс хассан. Эрүүл мэндийн байгууллагууд 100 хувь камерын хяналтыг бүрэн нэвтрүүлж, ажлын цаг | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | ашиглалтыг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан дүгнэдэг. | | |
| | 120 | | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | Эрүүл мэндийн сайдын А/406 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-мийн эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцааны горимд эмнэлгийн мэргэжилтнүүд өөр хоорондоо болон удирдлагын зүгээс эмнэлгийн ажилтнуудыг ялгаварлан гадуурхахгүй байхаар тусгасныг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар эрүүл мэндийн байгууллагуудын ёс зүйн баг, хорооноос ажилчиддаа сургалтыг тогтмол явуулж ажилласнаар эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцааны зөрчлүүд буурч байна.<br>Мөн байгууллагын дотоод журамд "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг баримтлан ажиллахыг ажилчдад үүрэг болгон мөрдүүлэн ажиллаж байна.<br>2023 оны хагас жилийн байдлаар эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой 2 гомдол ирснийг нөхцөл байдлыг тодруулан талуудаас тайлбар авснаар эвлэрүүлэн зуучилсан. | | |
| | 121 | | 3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн | Эрүүл мэндийн байгууллагууд Засгийн газрын 2018 оны 08 сарын 22-ны өдрийн А/258 дугаар тогтоолын дагуу дотооддоо хяналт шалгалтыг явуулснаас гадна төрийн албаны сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр гарсан тогтоол, захирамж, чиглэлүүдийг нийт ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж авсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэг тасгийн эрхлэгч, ахлах сувилагч чанарын багийн бүрэлдэхүүнтэй хяналтыг тасгууд нь дотооддоо хяналтыг хийж, ажлын байранд согтууруулах ундаа, тэсэрч дэлбэрэх бодис, хурц үзүүртэй зүйл агуулж буй эсэх, ажлын байрны эмх цэгц, ажлын цаг ашиглалт, ажлын цагаар ажлын байрандаа байгаа эсэх, гүйцэтгэлийг тус тус хянаж ажлын байр тус бүр дээр арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | ЭМГ нь байгууллагын ажлын ирцийн бүртгэлийг erp.e-mongolia цахим бүртгэлээр хийж байна.  | | |
| 36 | 122 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2019-10-30 Дугаар 2019_395 | 2.. Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд даалгасугай. | Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулалд 1037269,8 мянган төгрөг зарцуулсан. | | |
| 37 | 123 | Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-12-25 Дугаар 2019_474 | 1. Хүн амын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох, уялдаа холбоог нь сайжруулах болон ундны усны чанар, аюулгүй байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн | Сумын эрүүл мэндийн төвүүдийн 80 хувь нь ариун цэврийн шаардлага хангасан гүний худагтай бөгөөд 20 хувь нь сумын төвийн нэгдсэн гүний худгаас цэвэр усаа хангаж байна. Аймгийн төвийн 3 өрхийн эрүүл мэндийн төвийн 1 нь төвлөрсөн усан хангамжтай. Бусад нь зөөврийн усан хангамжтай байна. Сумын 6 эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төслийг аймгийн Засаг даргад хүргүүлэн дэмжигдэж, зураг төсөл нь хийгдэж байна.<br>2022 онд Архангай аймгийн ундны усанд хийгдсэн шинжилгээний үр дүнг орон нутгийн удирдлагуудад танилцуулсан.<br>“Нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015” стандартын нүхэн жорлонтой айл өрхийн тоог нэмэгдүүлэх зорилгоор сурталчилгааг тогтмол зохион байгуулан ажилласан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Ц.Нямдорж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (Ж.Батсуурь) нарт даалгасугай. | | | |
| 38 | 124 | Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106 | 1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хэвийн явуулж архивын баримт бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээнд 2022 оны байдлаар нийт 89 баримтыг бүртгэж авсан.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны 09 сарын 20-ны 5 дугаар "Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хамгаалах, хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" албан даалгаврын дагуу Архангай аймгийн Архивын тасгаас 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр улсын хяналтын шалгалтанд амжилттай шалгуулсан. | | |
| | 125 | | 2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | 2022-онд архивын баримтын хадгалалт хамгаалалтын стандарт бүрэн хангагдсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 39 | 126 | Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 2020-06-01 Дугаар 2020_206 | 3. Хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн тусламжийн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт тус тус даалгасугай. | МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын хүрээнд бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах талаар тусгасан.<br>Бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхдийг төрснөөс 3 хүртэлх насанд бие бялдар, хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг дэмжих асрахад зориулан “Нялх балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/571, А/637, А/218 дугаар хамтарсан тушаалаар баталсан хөтөлбөрийг ЭМБ-дад хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 40 | 127 | Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-11-18 Дугаар 2020_183 | 19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Архангай аймгийн ЗДТГ-ын Төрийн худалдан авах газартай хамтран эм, эмнэлгийн хэрэгсэл ороох боох материалын тендерт материал ирүүлсэн дотоодын үйлдвэрээ дэмжин хамтран ажилладаг.<br>2023 оны эм эмнэлгийн хэрэгслийн тендерт 34 багцад дотоодын үйлдвэрлэгчид хуулийн хүрээнд давуу эрх олгон ажилласан. | | |
| 41 | 128 | Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай | 1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чандлан баримталж үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж байна. Оны эхнээс санхүүгийн сахилга хариуцлагатай байх, хууль дүрэм журмаа сахин бүрэн мөрдүүлж ажиллах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021-02-17 Дугаар 2021_43 | арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдварын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай:<br>1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;<br>1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, | зааварчилгаа өгч харъяа байгууллагуудаа 7 удаагийн тоот албан бичгүүдийг хүргүүлэн ажиласан. ЭМС-ын хувьд 2023 оны 09 сарын 19-ний өдрийн байдлаар 246 сая төгрөгийн өртэй байсан ба зарим алслагдсан бөгөөд хүн ам багатай Цахир, Хоршоолол зэрэг сумдын ЭМТ-ийн хувьд нилээдгүй үүссэн өрийн асуудал барагдах боломжгүй цаашид улам нэмэгдэхээр байгаа тул үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй байдал үүссэн зарим ЭМБ-уудын өрийг шийдвэрлүүлэх саналыг тооцоо судалгаа гарган ЭМС Чинзоригт танилцуулан 2023.09.21 өдрийн 02/788 тоот албан бичгээр уламжилан хүргүүлсэний үр дүнд Цахир Хоршоолол, Төвшрүүлэх, Хашаат, Өгийнуур СЭМТ-үүдэд хийт 100,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг авч чадсан. 11-р сарын байдлаар салбарын хэмжээнд дутуу санхүүжилт авсан, мөн зарцуулах эрхийг хязгаарласаны улмаас 873 сая төгрөгний өр үүссэн байгаад дүгнэлт хийж холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр санхүүжилтээ бүрэн авах, төсөв мөнгөө зөв зохистой зарцуулах, өр авлагагүй ажиллах талаар анхааруулах албан бичгүүдийг, мөн ЭМЯ-нд 2023.11.09-нд 02/943, 13-ны өдрийн 02/948 тоот албан бичгээр холбогдон зарцуулах эрхийг нээлгэх, зарим ЭМБ-уудад төсвийн зохицуулалт хийлгэх саналыг тус тус хүргүүлэн ажилласны үр дүнд 11 сарын мэдээгээр өрийн хэмжээ 402,2 сая буюу өмнөх сараас 53 хувиар буурсан ба жилийн эцсийн байдлаар өр авлагыг бууруулах улмаар өр авлагагүй ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>2023 онд автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг төсвийн хөрөнгөөр хийгээгүй болно. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;<br>1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;<br>1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;<br>1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;<br>1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;<br>1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;<br>1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;<br>1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах. | | | |
| 42 | 129 | Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-03-17 Дугаар 2021_67 | 2. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан 2023 оны 11 сарын байдлаар ХМК-ын 44 удаагийн хурал, нүүдлийн 2 удаагийн хурлыг зохион байгуулан нийт 3416 иргэн хамруулсан.<br>Үүнд: 261 иргэнийг шинээр тогтоон, 239 иргэнийг цуцалж, шилжиж ирсэн 5, шилжиж явсан 10, нас барсан 46, 2855 иргэний сунгалтыг хийсэн байна. | | |
| | 130 | | 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан холбогдох дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан 2023 оны 11 сарын байдлаар ХМК-ын 44 удаагийн хурал, нүүдлийн 2 удаагийн хурлыг зохион байгуулан эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд мэдээлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | С.Энхболд, Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цахимаар хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | | | |
| | 131 | | 4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2023 оны 11 сарын байдлаар хөдөлмөр магадлах комиссын 44 удаагийн хурал, нүүдлийн 2 удаагийн хурлыг зохион байгуулан нийт 3416 иргэн хамруулсан байна.<br>Үүнд: 261 иргэнийг шинээр тогтоон, 239 иргэнийг цуцалж, шилжиж ирсэн 5, шилжиж явсан 10, нас барсан 46, 2855 иргэний сунгалтыг хийсэн байна. | | |
| 43 | 132 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай<br>2021-04-08<br>Дугаар 2021_93 | 5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Ажлын хэвийн горимоор ажиллаж байгаа тул цар тахалтай холбоотой төрөл бүрийн цалин урамшуулал мөнгөн тэтгэмж олгоогүй. Өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллаж байна. | | |
| 44 | 133 | Хөгжлийн | 2. Орон нутаг дахь Хөгжлийн | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бэрхшээлтэй хүний хөгжлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-06-16 Дугаар 2021_164 | бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах ажлыг хамтран зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, салбарын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг энэ тогтоолын 1-д заасан аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | баригдаж байгаа бөгөөд барилгын явц одоогоор 40 хувьтай байна.<br>Төвд ажиллах шаардлагатай тэр тусмаа сэргээн засах чиглэлээр ажиллах боловсон хүчний судалгааг хийж, мэргэжлийн хүмүүстэй уулзаж санал солилцох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг сургуулиудад төлбөрийн хөнгөлөлттэй сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах зэрэг ажлыг төлөвлөн шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>АШУҮИС-д хөдөлмөр засалч, хөдөлгөөн засалч мэргэжлээр 2 хүнийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн төвд ажиллах хүчнийг бэлтгэж байна.<br>Аймгийн НЭ-ийн уламжлалт сэргээн засах тасагт мэргэжлийн сэргээн засалч эмч ажиллаж байна. | | |
| 45 | 134 | Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2021-07-28 Дугаар 2021_221 | 2.7. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хадлан тэжээл бэлтгэл, ургац хураалтын ажилд оролцож байгаа аж ахуйн нэгж, иргэдэд халдвар хамгааллын урьдчилан сэргийлэх горим, дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд харъяа нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгжид коронавируст халдвараас сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгсөн. | | |
| 46 | 135 | Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай 2021-10-13 | 3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж | Эрүүл мэндийн газрын 2023 оны хагас жилийн үндсэн хөрөнгө, эд матиериалын тооллогыг 2023 оны 06 сарын 29, 30-ны өдрүүдэд С.Энхтуяа, Б.Болормаа, Р.Ариунжаргал нарын бүрэлдэхүүнтэй хийж | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2021_315 | байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | гүйцэтгэсэн. Тооллогыг хүн тус бүрийн эзэмшиж байгаа хөрөнгийн карттай тулгаж, няравын агуулахад байгаа эд хөрөнгийг байгууллагын нөөц болон бараа материалын тайлантай тулган нэг бүрчлэн тоолов. Тооллого хийхэд тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бараа материал нь илүүдэл, дутагдалгүй бүрэн тоологдсон болно. | | |
| 47 | 136 | Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай 2013-02-02 Дугаар 05_2013_37 | 4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургууль болон сургуулийн багштай хамтран ажилчдад монгол бичгийн эрчимжүүлсэн сарын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. | | |
| 48 | 137 | “Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022.12.07-ны өдрийн 448 дугаар тогтоол | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангаж хэт төвлөрлийг бууруулах, батлагдсан төсвийг үр дүнтэй, үр ашигтай зарцуулах | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ батлагдсан төсөвтөө багтаан төсвийг үр ашигтай зарцуулж өр авлага гаргалгүй чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлж байна. Үйл ажиллагаанд төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж үр ашиггүй зарлага гарахаас урьдчилан сэргийлж, байгууллагын хэмнэж болох бичиг хэргийн зардал болон бусад зардлуудыг хэмнэн ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд оновчтой үр дүнтэй санхүүжүүлэх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, өр төлбөр үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төсвийн сахилга бат, хариуцлагагыг чангатгах арга хэмжээ авч ажиллахыг ЭМСайд С.Энхболдод | | | |
| | 138 | | 1.6.2017-2021 онуудад хэрэгжүүлсэн "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөний үнэлгээг хийсний үндсэн дээр. хөтөлбөрийг 2023 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод; | “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулахаар төлөвлөсөн. Тус хөтөлбөрийн хүрээнд 2023 онд аймгийн хэмжээнд нийт 2965 хүнийг элэгний С вирүс, 3103 хүнийг элэгний В вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулан anti-HCV эерэг 188 тохиолдол, HBsAg эерэг 210 тохиолдлыг тус тус илрүүлэн хяналтад авсан. Элэгний В, С вирустай илэрсэн иргэдийг идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамруулан С вирусын эмчилгээнд 20 хүн, В вирусын эмчилгээнд 11 хүнийг тус хамруулсан. | | |
| | 139 | | 1.7 төсвийн санхүүжилтийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах төрийн өмчит эрүүл | Эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтыг орон нутгийн өмчийн газраар нээлттэйгээр зарлуулан эмийн тендерт шалгарсан ЭХНТ-тэй гэрээ байгуулж батлагдсан татан авалт эхэлсэн байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэндийн байгууллагын төлөвлөн удирдах зөвлөлийг байгуулах болон эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо бүрдүүлэх талаар Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн биелэлтийг хангаж, зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын явц үр дүнг танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод; | Эм,эмнэлгийн хэрэгслийн тендерт үндсэн тендерээс 34 багц, ерөнхий гэрээнд 1 багцыг заралснаас 18 багцад 8 эм ханган нийлүүлэх төвүүд шалгарсан бөгөөд эмийн хангалт нийлүүлэлтийг заасан хугацаанд хүлээн авч СЭМТ-үүдэд захиалгын дагуу хүлээлгэн өгсөн. Тендерт шалгараагүй тендерийн багцуудыг ЭХНТ-үүдтэй шууд худалдан авалтын гэрээг байгуулан эм,эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсхээс урьдчилан сэргийлж эмийн хангалт нөөцийг бүрдүүлэн ажилласан. | | |
| | 140 | | Төсвийн хөрөнгө, оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.<br>2.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байхгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 141 | | 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; | Эхний 4-р улирлын байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй. | | |
| | 142 | | 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; | Эхний 4-р улирлын байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ямар нэгэн зарцуулалт хийгдээгүй болно. | | |
| | 143 | | 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn )-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах | 2023 онд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын санал боловсруулан ЭМЯ, Аймгийн засаг даргын тамгын газар болон УИХ-гишүүдэд албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтад 456,2 сая, барилгын засвар үйлчилгээнд Орон нутгийн төсвөөр 249,1сая, Улсын төсвөөс 14.8 тэрбум нийтдээ 15,8 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус шийдвэрлэгд хэрэгжүүлсэн. 2024 оны төсвийн төслийг боловсруулан аймгийн ЗДТГ-т www.publicinvestment.gov.mn шивж оруулсан хүргүүлэн хүргүүлэн ажилласан. | | |
| 49 | 144 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах | Оюутан залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэн, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Эерэг хандлага, Эрүүл оюутан” аяны удирдамж батлуулан оюутан, залуучуудад эрүүл мэндийн даатгал төлөлтийн ач холбогдлыг таниулах, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдалтыг | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | нэмэгдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг ажлуудыг төлөвлөн 120 гаруй оюутан залуучуудын эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүдлсэн.<br>"Бидний ирээдүй-бидний гарт" сургалт, нөлөөллийн арга хэмжээг аймгийн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж 790 сурагчийг сургалтанд хамруулан электрон тамхины хэрэглээг багасгах, цахим орчны хэрэглээг зөв зохистой ашиглах зэрэг сэдвүүдээр эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүллээ.<br>Аймгийн эрүүл мэндийн Газрын цахим хуудсаар дамжуулан 09-р сард 80 гаруй төрлийн эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл бүхий зурагт хуудас, видео контентийг нийтлэн цахим хэлбэрээр эрүүл мэндийн сурталчилгааг иргэдэд хүргэсэн. Цахим хуудсаар дамжуулан нийтэлсэн мэдээлэл 15600 гаруй иргэнд хүрсэн байна. | | |
| 50 | 145 | "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322 | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Чулуут, Тариат, Ихтамир, Эрдэнэбулган сумын ЕБС-ийн сурагчдад "Амны хөндийн эрүүл мэнд", "Эрүүл ахуй -Эрүүл дадал" сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулсан. Сургалт нөлөөллийн ажилд 900 гаруй сурагч хамрагдаж мэдлэгээ сайжруулсан.<br>"Мишээл сан" ТББ- тай хамтран Цахир, Хангай сумдын 0-17 насны хүүхдүүдийн дундах шүдний өвчлөлийг бууруулах төслийг 2023 оны 11 сард хэрэгжүүлэн 1100 хүүхдэд үзлэг эмчилгээ хийсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хэсгийн дундаж хувь 95.2% | | | | | | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | |
| 51 | 146 | 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2018-04-25 Дугаар 2018_18 | XX.1.Япон Улсын Токио хотод 2018 оны 4 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулсан “Өвчтөний аюулгүй байдлын асуудлаарх дэлхийн сайд нарын 3 дугаар чуулга уулзалт”-д оролцсон дүнгээ Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Тус чуулга уулзалтаас гаргасан “Өвчтөний аюулгүй байдлын асуудлаарх Токиогийн тунхаглал”-ыг хэрэгжүүлэх талаарх үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд даалгав. | Эрүүл мэндийн байгууллага бүр ЭМС-ын 2019 оны А/566 дугаар тушаал эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, давтан гарахаас сэргийлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад онцгой анхаарч ажиллаж байна.<br>Мөн ЭМС-ын 2022 оны А/352 тоот тушаалыг үндэслэн байгууллагын үндсэн тусламж үйлчилгээ чиг үүргийн хүрээнд үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, танин тодруулгыг байгууллагын даргын тушаалаар албажуулан "Үйлчлүүлэгчийн зөв танин тодруулах журам"-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тухайлбал: Нэгдсэн эмнэлэг үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгад ашиглах хувь хүний өвөрмөц мэдээлэл бүхий өнгөөр ялгасан 1 удаагийн хэрэглээний зориулалтын 4 өнгийн туузан бугуйвчийг тусламж үйлчилгээндээ хэрэглэж хэвшсэн. | | |
| 52 | 147 | 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2020-04-15 Дугаар 2020_24 | XXIII.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг томилгоожуулж, албажуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд даалгав. | Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийт 1285 ажилтан ажиллаж байна. КОВИД-19 цар тахлын тархалтын түвшинг сум бүрээр тооцон гаргаж, ажиллах хүн хүний тооцоолол судалгааг 8 долоо хоногоор тооцоолон гаргасан.<br>“КОВИД-19” цар тахлын үеийн тусламж үйлчилгээнд улаан бүсэд ажиллах эмч, сувилагч, үйлчлэгч нарын хуваарийг ЭМГ-ын даргын тушаалаар 3 удаа (ЭМГ-ын даргын 2020 оны А/51, А/57, А/163, 2021 оны А28) шинэчлэн томилж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Мөн КОВИД-ын нөхцөл байдал хүндэрсэн эрүүл мэндийн байгууллага хооронд хүний нөөцийг дайчлан ажиллах хуваарийг 2 удаа (ЭМГ-ын даргын 2021 оны 03 сарын 25-ны А/26, 2021 оны 06 сарын 13- | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ны А/121) гарган нийт 38 эмнэлгийн ажилтныг дайчлан ажиллуулсан.<br>Эрүүл мэндийн салбарын нөөцөд бүртгэлтэй эмч, сувилагч тусгай мэргэжилтнийг дайчлан ажиллуулах хуваарийг ЭМГ-ын даргын 2021 оны 128 тоот тушаалаар батлан үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.<br>КОВИД-19 цар тахлын тусламж үйлчилгээний үед хавьтлын сорьц цуглуулах, хавьтлын тандалт судалгаа хийх, голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хүний нөөцийн хомсдол үүссэнтэй холбоотой ЭМХТ-өөс түргэвчилсэн богино хугацааны сургалтуудыг зохион байгуулсан. Уг сургалтуудад тархвар судлалын түргэвчилсэн 4 хоногийн сургалтад нийт 42 хүнийг, ариутгагчийн түргэвчилсэн 5 хоногийн сургалтад 28 хүнийг, лабораторийн түргэвчилсэн 5 хоногийн сургалтад 28 хүнийг тус тус хамруулсан. | | |
| 53 | 148 | 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 28 дүгээр тэмдэглэл<br>2020-04-29<br>Дугаар 2020_28 | IX.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах. | Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5-д заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилчид болон 3 ба 5-жилийн тэтгэмжийг жил бүрийн төсөвтөө суулган ЭМЯ болон Сангийн яаманд жил бүр хүргүүлэн ажилладаг. | | |
| 54 | 149 | 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 61 дүгээр тэмдэглэл<br>2020-11-13<br>Дугаар 2020_61 | I. . Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй | 2023 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд цочмог халдварт өвчний нийт 377 тохиолдол батлагдсан. Цочмог халдварт өвчний 112 тохиолдол буюу 29.7% нь коронавируст халдвар эзэлж байна. Коронавируст халдварын батлагдсан тохиолдлуудын тандалт судалгаа хийн хавьтлыг тогтоон тусгаарлан | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа шуурхай хариу арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан коронавируст халдвар илэрсэн тохиолдлын хавьтлыг илрүүлэх, тусгаарлах ажлыг эрчимжүүлэх, улсын хэмжээнд хүнсний хомсдол үүсгэхгүй байх, эмзэг бүлгийн иргэд, дотуур байрны сурагч, оюутнуудыг хүнсээр хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, халдварын голомтод ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдад урамшуулал олгох, гэмт хэрэг, эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав." гэжээ. | сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хяналтандаа авч ажиллаж байна. Коронавируст халдварын батлагдсан тохиолдлуудын 100% эмчилсэн. | | |
| 55 | 150 | 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 66 дугээр | XII.2. 5. Вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг батлах, | Ковид-19 цар тахлын өвчлөл багассантай холбогдуулан дархлаажуулалт хийгдээгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2020-11-25 Дугаар 2020_66 | хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт. | | | |
| 56 | 151 | 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69 | Ү. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав. | Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд цахим мэдээллийн сангаар дамжуулан, төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia платформоос ковидын вакцины гэрчилгээ, ковидын шинжилгээний хариу, эрт илрүүлэгийн хариу, шинжилгээний хариу, эмнэлгийн цаг авах үйлчилгээнүүд иргэд авах боломжтой. | | |
| 57 | 152 | 2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2021-02-14 Дугаар 2021_10 | I.2. 4. Иргэдийг вакцинжуулах ажлыг эрчимжүүлэх зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээ авч, харилцан уялдаатай ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга | Ковид-19 цар тахлын өвчлөл багассантай холбогдуулан дархлаажуулалт хийгдээгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Д.Сумъяабазар нарт, Энэтхэг улсаас вакцин татаж авах ажиллагааг 2 дугаар сарын 23-ны дотор багтааж зохион байгуулахыг Шадар сайд С.Амарсайханд, вакциныг Монголд авч ирэх тээврийн зардлыг шийдвэрлэх саналаа Засгийн газрын 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | | | |
| 58 | 153 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Хүний нөөцийн сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг hr.hdc.gov.mn –ээр дамжуулан цахимаар авч хэвшсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн хүсэлтийг backend acc.hdcd.gov.mn–ээр илгээж байна.<br>Тусгай зөвшөөрөлтэй холбоотой 8 төрлийн үйлчилгээг e-mongolia-д нэвтрүүлсэн бөгөөд ЭМГ-ын цахим хуудаст бүрдүүлэх материал болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ зэрэг холбогдох шаардлагатай мэдээллийг ид тод байршуулсан.<br>Мөн ЭМГ-ын мэдээллийн самбар энэ талаар мэдээллийг байршуулан ажиллаж байна. | | |
| 59 | 154 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр | II. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах | Архангай аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн барилгын цэвэр бохир усны шугамын шинэчлэлд 54 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19 | зарим арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.<br>2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав. | сая, Хоршоолол сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварт 45 сая төгрөгийн эрх шилжүүлэн засварын ажил бүрэн хийгдэж дууссан.<br>2023 онд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр Тариат сумын эрүүл мэндийн төвийн гадна бохирын шугамд цэвэрлэх байгууламж суурилуулах ажлид 80 сая төгрөг шийдвэрлэгдэн засварын ажил бүрэн хийгдэж дууссан. | | |
| | 155 | | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын | Салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй барилга байгууламж байхгүй байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | | | |
| 60 | 156 | 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл 2021-07-20 Дугаар 2021_43 | XIII.2.5. Хичээлийн шинэ жилийг эхлүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан коронавирусын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, тариаг иргэд эмийн сангаас шууд худалдан авах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав. | Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотойгоор Ковид-19 -ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх түргэвчилсэн оношлуур, эм тариаг хүртээмжтэй хүргэх үүднээс ЭМГ-ын даргын тушаалаар эмийн сангуудыг уртасгасан цагаар ажиллуулах, хүргэлтээр үйлчлүүлэх зохицуулалтыг хийсэн. Мөн тус 2 газар хамтын гэрээ байгуулан эм тариа, түргэвчилсэн оношлуурын шууд худалдан хийж ажиллаж байна. | | |
| 61 | 157 | 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48 | XYI.4. . Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав. | Эрүүл мэндийн сайдын 139 дүгээр тушаал, ЭМДҮЗ-ийн 6-р тогтоолын дагуу “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв” дээр 18-аас дээш насны иргэдийг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Аймгийн хэмжээнд нийт 34407 буюу 36.1 хувь нь хамрагдсан байна.<br>Эрт илрүүлгийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын А/66 тоот тушаал гаргаж, арга аргачлал, зөвлөмжөөр хангаж ажиллах “1 мэргэжилтэн-1 ЭМТөв” шийдвэр гарган хариуцуулав.Эрт илрүүлэгт хүн ам нь хамгийн өндөр хамрагдалттай Чулуут сумын ЭМТөвийн сайн туршлагыг бусад сум өрхийн ЭМТ-ийн эрхлэгч эмч нарт танилцуулж туршлага судлуулав.“Эрт илрүүлж эрчимтэй сэргийлье” уриатай цахим | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сурталчилгаа, Орон нутгийн “АВ” телевизээр эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдахын ач холбогдолын талаар багц мэдээллийг нэвтрүүлсэн.2023 оны 08 дугаар сараас 10 сарын хооронд сумын ЗДТГ-уудад эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалтын мэдээ, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд ЭМТ-тэй хамтарч ажиллах тухай албан бичгийг 2 удаа хүргүүлсэн .Сум өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн нийт 18 эмч нарт хүүхдийн эрт илрүүлгийн мэдээллийг танилцуулж, эрчимжүүлэн ажиллахыг үүрэг болгосон. “18-34-насны залуучуудыг эрт илрүүлэг үзлэгт хамгийн сайн хамруулсан ЭМБ” болзолт уралдааныг зарласан.18-35 насны залуучууд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт ЭМД төлөгдөөгүйн улмаас хамрагдалт муу байгаа тул 18-35 насны залуучууд, малчин, ажилгүй иргэдийг эрүүл мэндийн албан журмын даатгалд хамруулах аян зохион байгуулахаар аймгийн засаг даргын захирамж боловсруулан бүх сумдын ЗДТГ-т хүргүүлсэн. “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”-ын хүрээнд аймгийн НЭ дээр МУБИС-ийн харьяа Багшийн сургуулийн 108 оюутан буюу 36 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан.Архангай аймгийн Боловсролын газартай хамтран 2023 оны хичээлийн жилд 1-дүгээр ангид элсэн суралцаж байгаа 6 настай хүүхдүүдийн үзлэгийг сургуулийн орчинд суурилсан эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулан нийт 1330 хүүхдийг эрт илрүүлэгт хамруулав. Эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтын мэдээ, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад сар бүр хүргүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 62 | 158 | 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49 дүгээр тэмдэглэл 2021-08-31 Дугаар 2021_49 | XIII.4.5. Аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах саналыг судалж, шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод. | Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 500 сая төгрөгийн өртөг бүхий хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулсан. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр нь ашиглалтад орсноор ковидын тусгай эмнэлэг болон хэвтэн эмчлүүлэх тасгуудад хүчилтөрөгчийн хангамжийг цаг алдалгүй түргэн шуурхай хүртээмжтэйгээр үйлдвэрлэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглаж байна. | | |
| | 159 | | XҮ.6.2. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын хэрэгцээнд ашиглагдаж байгаа 2014 оноос өмнө худалдан авсан 196 автомашин, сумдын эмнэлгийн үйлчилгээний 98 автомашиныг ашиглалтын зохих норм норматив, стандартыг харгалзан үе шаттайгаар шинэчлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; | Эвдрэл гэмтлийн улмаас түргэн тусламжийн үйлчилгээнд явах боломжгүй болсон сумдад авто машин олгох хүсэлтийг ЭМЯ, албан бичгээр хүргүүлж 2023 оны жилийн эцсийн байдлаар хувь хүний хандиваар Хотонт, Цэнхэр, Хайрхан сумдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Цахир сумын эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлт хийгдсэн. Мөн Нэгдсэн эмнэлэгт эрт илрүүлгийн явуулын үзлэгийн авто машин, Эрдэнэмандал сумын эрүүл мэндийн төвд мэргэжлийн хяналтын газрын авто фургон автомашиныг шилжүүлсэн салбарын хэмжээнд 480 гаруй төгрөгийн өртөг бүхийн нийт 6 автомашины хангалт хийгдсэн. Цаашид нэн хэрэгцээтэй байгаа гурван эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн авто машины хангалт хийх хүсэлтийг ЭМЯ-нд албан бичгээр уламжилсан. | | |
| | | | XII.6. Газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. | Аймгийн эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй нийт барилга байгууламжаас газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй насжилт дууссан барилга буюу Зоонозын өвчин судлалын төвийн барилгыг шинээр барих хэрэгцээтэй байх тул энэ талаар холбогдох байгууллагад санал хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 63 | 160 | 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58 | Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолын хавсралтад заасан газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | |
| | 161 | | XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд шинээр барих, их засвар хийх, өргөтгөх барилга байгууламжийн саналыг боловсруулан ЭМЯ, аймгийн Засаг даргын тамгын газрын ХБТХОХэлтэс, ИТХ-ын даргад 3 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.<br>Монгол усыг хөгжүүлэх таван үндсэн чиглэлд тусгуулах эрүүл мэндийн салбарт шаардлагатай барилга хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг 2020 -2024 он хүртэл 4 жилээр боловсруулан ЗДТГазарт | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | хүргүүлсэн. | | |
| 64 | 162 | 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бух шатны Засаг дарга, бух шатны терийн байгууллагын удирдлагад үүрэг болгов: | Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP, байгууллагуудын албан бичиг солилцох ABLE систем, төрийн албаны цахим шуудан, yahoo, gmail гэх мэт цахим мэдээлэл солилцооны 4 платформоор холбогдох албан бичгүүдийг мэдээллээ солилцдог. | | |
| | 163 | | 2. Төрийн байгууплагын албан хэрэг хөтлөлтийн цахим системийн аюулгүй байдлыг хангаж, кибер халдлага, - зөрчлөөс сэргийлж ажиллахыг. Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т, цахим системийн хэвийн үйл ажиглагазг хангаж ажиллахыг "И-Монгол академи" УТУГ-ын захирал Л.Энхбатад тус тус даалгав | Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дугаар тушаалыг дагаж, мөрдөж ажилладаг.<br>Албан бичгийн аюулгүй байдлыг ханган эрх бүхий 1 ажилтан /бичиг хэргийн ажилтан/ хандаж албан бичгийн дамжуулж, хөтөлж ажилладаг. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 65 | 164 | "Төсвийн ерөнхийлөн захирагч нарт" 2023.02.08-ны өдрийн 08 дугаар тэмдэглэл Дугаар 2023_08 | 2. Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ, батлагдсан төсвийн багцын дүнд хийгдсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалтын арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагчид даалгав гэжээ. | Аймгийн Нэгдсэн эмнэлэг шинээр баригдаж байгаатай холбогдуулан шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн жагсаалтыг боловсруулан ЭМЯ, Засаг даргын тамгын газрын ХБТХОХэлтэст тус тус албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 66 | 165 | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл "Аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт" 2023.03.07 өдрийн 11 дүгээр тэмдэглэлд | XII.2.Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1.Хүн амыг арт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажилпагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг ЭМСайд С.Чинзориг, аймаг | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах" 2022 оны 6 дугаар тогтоолын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн "Эрүүл мэндийг дэмжих төв" дээр 18-аас дээш насны иргэдийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 25862 хүн хамрагдсан. Монгол улсын Засгийн Газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичиг, БХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг"-ийг Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторийн 4 ээлжийн 82 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, техникч, жолооч нар 98 хоногийн хугацаанд Архангай аймгийн 18 суманд нийт 8155 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/256 дугаар тушаалыг дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн явуулын үзлэг Эрдэнэмандал, Тариат, Эрдэнэбулган суманд нийт 5 өдөр ажилласан.Үзлэгт нийт эрт | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт 2.Хүн амым эрүүл мэндийн боловоролыг дэмжих, амьдралын эрүүл хэв маягийг төлөвшүүлэх, оюутан сурагчдын эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах боломжийг бүрдүүлэх чиглэлээр хамтарч ажиллахыг Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт:<br>3. Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил харилцаа холбооны сайд Н.Учрал нарт:<br>4. 2024 онд “Шүд” төсөл хэрэгжүүлэх, энэ хүрээнд Нүүр ам судлалын Үндэсний төвийг байгуулах талаар судалж, танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт: | илрүүлэг үзлэгт 390 хүн хамруулсан.Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт 34407 буюу 36.1 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна.Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 1 иргэнд тооцож олгосон санхүүжилтээр 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, нийт 19307 хүүхэд үзлэгт хамрагдсанаас 39 хувь нь эрүүл, 61 хувь нь өвчтэй байна. 0-5 насны хүүхдийн өвчлөлийн 80 хувь, 6-17 насны хүүхдийн 88 хувь нь шүд цоорох өвчлөл эзэлж байна. Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”-ын хүрээнд аймгийн НЭ дээр МУБИС-ийн харьяа Багшийн сургуулийн 108 оюутан буюу 36 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан. 18-35 насны залуучууд, малчин, ажилгүй иргэдийг эрүүл мэндийн албан журмын даатгалд хамруулах аян зохион байгуулахаар аймгийн засаг даргын захирамж боловсруулан бүх сумдын ЗДТГ-т хүргүүлсэн. | | |
| | 166 | | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, | ЭМС-ын Жендэрийн салбар хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>ЭМГ, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | мэргэжилтэн нийт 25 хүн жендэрийн талаарх мэдлэгээ сайжруулах сургалтанд хамрагдсан.<br>Эрүүл мэндийн байгууллагууд “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д нэгдэж, хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах сургалт нөлөөллийн ажлыг хийлээ.<br>- Аяны уриа, мэдээлэл болон “Жендэрийн үндэсний хороо”, “ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”, “ЦЕГ-ын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”, ЭМЯ зэрэг фэйсбүүк пэйж хуудсанд нийтлэгдсэн видео болон бусад контент, постерыг байгуулагынхаа албан ёсны цахим, фейсбүүк хуудаст хуваалцаж олон нийтэд түгээсэн.<br>-“Цагаан туузтан”-ы хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж, байгууллагын ажилтан албан хаагчдад жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдээ мэдээлэлийг хүргэсэн.<br>- Эрүүл мэндийн байгууллагууд “Хүндлэл - Хамгийн том гэрэл” уриан дор жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны удирдамжийн дагуу зохион байгуулсан.<br>“Эрчүүдийн эрүүл мэндэд эмэгтэйчүүдийн оролцоо” сургалт нөлөөллийн ажлыг Өндөр-Улаан сумын ЭМТ-тэй хамтран зохион байгуулсан сургалтанд 80 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэсэн.<br>“Хүндлэл - Хамгийн том гэрэл” уриан дор жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд эрүүл мэндийн байгууллагын 15 хос залуусыг “Хос зүрх” сургалтанд хамруулсан. | | |
| Хэсгийн дундаж хувь 99% | | | | | | |
| **ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 67 | 167 | Төлөвлөгөө батлах тухай 2020-07-01 Дугаар 2020_99 | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтын шалтгаанд сүүлийн 5 жилийн байдлаар үнэлгээ хийхэд хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, зүрх, судасны өвчлөл, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин зонхилж байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад эмнэлгт 2 дахин цөөн ханддагтай холбоотой нийт хүн амын өвчлөлийг хүйсээр авч үзэхэд 65 хувь нь эмэгтэйчүүд, 35 хувь нь эрэгтэйчүүд байна.<br>Эрэгтэйчүүдийн нас баралтын шалтгаанд зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчин, хавдар, осол гэмтэл, гадны шалтгаант өвчин зонхилж байна. Нийт нас баралтын 64 хувь нь эрэгтэйчүүд, 36 хувь эмэгтэйчүүд эзэлж байна. Хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 32 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эмэгтэйчүүдээс 1.6 дахин бага байна.<br>Иймд ЭМС-ын 2022 оны А/139 дүгээр тушаал, ЭМДҮЗ-ийн 2022 оны 6 дугаар тогтоолоор хийж буй даатгуулагчийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд эрэгтэйчүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх болзолт уралдааныг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд зарласан.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт урологи-андрологийн чиглэлээр эмч, сувилагчийг мэргэшүүлэн “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет” ажиллуулж, 2023 онд 104 эрэгтэйд мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.<br>Эрэгтэйчүүдийг архи, тамхины хорт зуршлаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор архи, тамхины эсрэг цахим сурталчилгааг Эрүүл мэндийн газрын болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсаар хийж байна.<br>Өсвөр насны хөвгүүдэд “Өсвөр нас эрүүл мэнд”, Өсвөр нас –НҮЭМ”, “ Архи тамхины хэрэглээ”, “Дэлгэцийн донтолт” зэрэг сэдвээр 8 удаагийн сургалт хийж 400 хүүхдийг хамруулан мэдлэгийн сайжруулсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрчүүд олноор ажилладаг Ундарга болон эрчим хүчний байгууллагын эрчүүдэд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийж , зөв зохистой хооллолт, эрчүүдийн эрүүл мэнд, архи тамхины хэрэглээ, НҮЭМ сэдвээр сургалт хийж мэдээлэлээр хангасан. Сургалт, судалгаанд хүн хамрагдсан. | | |
| 68 | 168 | | XIII.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн хэмжээнд тогтоосон бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.<br>2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: 2.1. Эрүүл мэндийн салбарын хүчин чадал, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, хүний нөөцийн судалгааг дахин нягталж, бэлтгэл, бэлэн байдлыг хангах; 2.2. Полимеразийн гинжин урвал (PCR)-ын шинжилгээ хийх лабораторийн тоог нэмэгдүүлэх, шинжилгээний хариу гарах хүчин чадлыг өдөрт 100.000-д хүргэх, урвалжийн 2-3 сарын нөөц | Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тохиолдол бүрт түргэвчилсэн шинжилгээ хийх нөөцийг бүрдүүлсэн. Томуу, томуу төст өвчин ихэссэнтэй холбоотой Вирусийн болон антибиотикын төрлийн эмийн нөөцийг бүрдүүлэх эмийн тендерийн захиалгад тухайн нэн шаардлагтай эмийн захиалгыг нэмэгдүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэх; 2.3. Бүх шатны онцгой комисс болон яам, агентлагууд гаргасан шийдвэрийнхээ гүйцэтгэлд хяналт шалгалт хийх; 2.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв, хилийн боомт, өвчин гарсан газруудад халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж, хяналтыг сайжруулах; 2.5. Цар тахлын талаарх үнэн зөв, бодит мэдээллийг иргэдэд цаг алдалгүй хүргэх, халдвараас урьдчилан сэргийлэх мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх; 2.6. Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах. | | | |
| Хэсгийн дундаж хувь 90% | | | | | | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ДААЛГАВАР** | | | | | | |
| 69 | 169 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03 | 1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | Эрүүл мэндийн байгууллагууд цахим системүүдийг ашиглан иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй тарифаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. eHealth, health.gov.mn системүүдээр их эмч нар хөнгөлттэй эм бичиж, иргэд эмийн сангуудаас хөнгөлттэй тарифаар үйлчилгээг авдаг. Эмийн сангууд иргэдэд цахим төлбөрийн баримтыг /ebarimt/-аар олгодог. | | |
| | 170 | | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан | ЭМДЕГазраас “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй тусламж үйлчилгээг health.gov.mn програмд бүртгэх цахим хөгжүүлэлт” сэдэвт сургалтууд ЭМГ, Сум, Өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаагийн цахим сургалт хийж, эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд идэвхитэй хамрагдсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | таниулах. | | | |
| | 171 | | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан арга хэмжээний үеэр ЭМГ-ын ажилчид тоон гарын үсэг авсан. | | |
| | 172 | | 1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнүүдэд цахим даатгалаар хэвтэн эмчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ, өндөр өртөгтэй оношлогоо шинжилгээ, яаралтай тусламж, түргэн тусламж, өдрийн эмчилгээ, диализын үйлчилгээ, сэргээн засал, хөнгөвчлөх үйлчилгээ, уламжлалт анагаах ухааны үйчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт, ковид вакцин, ковид хэвтэн, ковид өрхийн үйлчилгээнүүдийг цахимд шилжиж даатгалаар санхүүжилтээ авч байна. | | |
| 70 | 173 | | 1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт<br>1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | Ай си ти групп ХХК-ийн санал болгож буй эрүүл мэндийн систем нь одоо ашиглаж буй систем, програмуудтай давхцал үүсч, дахин шивэлт, мэдээлэл оруулах эмч, эмнэлгийн ажилчдад чирэгдэл үүсэх ашиглах боломжгүйг мэдэгдсэн ЭМГ-ын 2023 оны 04 дугаар сарын 24-ны 02/376 албан тоотоор Аймгийн Засаг даргын орлогч, ICT Group-д хүргүүлсэн болно. Эрүүл мэндийн салбарт техник хангамжийг сайжруулах талаар санал өгсөн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 174 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд цахим мэдээллийн сангаар дамжуулан, төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia платформоос ковидын вакцины гэрчилгээ, ковидын шинжилгээний хариу, эрт илрүүлэгийн хариу, шинжилгээний хариу, эмнэлгийн цаг авах үйлчилгээнүүд иргэд авах боломжтой. | | |
| | 175 | | 1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | ЭМДЕГазраас “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй тусламж үйлчилгээг health.gov.mn програмд бүртгэх цахим хөгжүүлэлт” сэдэвт сургалтууд ЭМГ, Сум, Өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаагийн цахим сургалт хийж, эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд идэвхитэй хамрагдсан. | | |
| | 176 | | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | Эрүүл мэндийн байгууллагууд лавлагаа тодорхойлолтыг шалган нягталж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээллүүдийг хүргэдэг. | | |
| | 177 | | 1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, | Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэх цахим систем, програмуудад иргэдийн мэдээллийг ХУР системээс шалган эмнэлгийн тусламж үйлчилгээг найдвартай, хэвийн явуулж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | | | |
| | 178 | | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд цахим мэдээллийн сангаар дамжуулан, төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia платформоос ковидын вакцины гэрчилгээ, ковидын шинжилгээний хариу, эрт илрүүлэгийн хариу, шинжилгээний хариу, эмнэлгийн цаг авах үйлчилгээнүүд иргэд авах боломжтой. | | |
| | 179 | | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn/, төрийн байгууллагын ABLE, төрийн албан хаагчийн цахим шуудан mail.gov.mn системүүдээр эрүүл мэндийн салбарууд, төрийн байгууллагуудтай албан бичгээ дамжуулан солилцож байна. | | |
| Хэсгийн дундаж хувь 94.5% | | | | | | |
| Нийт дундаж хувь 94.6% | | | | | | |